

2017 оны 2-р сарын 19-нд Монгол Улсын эрх баригчидтай 314.505 сая зээлжих тусгай эрх (Монгол Улсын квотын 435 хувь) буюу ойролцоогоор 440 сая ам. долларын, гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх тохиролцоонд ажлын хэсгийн түвшинд хүрсэн талаар ОУВС-гаас мэдэгдсэн. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг ОУВС-гийн Захирлуудын зөвлөл баталснаар эрх баригчдын макро эдийн засгийн тогтвортой байдлыг сэргээж, эрчимтэй, тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангахад чиглэсэн эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх болно. Төсвийн сахилга бат, хэмнэлтийг хөхиүлэн дэмжиж, санхүүгийн салбарыг нөхөн сэргээн, хөрөнгө оруулалт, ажил эрхлэлтийг дэмжиж, эмзэг бүлгийг хамгаалахад чиглэсэн нийгмийн хамгааллыг тогтолцоог бэхжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршиж байна.

## Монгол Улс ба ОУВС

### *Асуулт 1: ОУВС-гийн зээл Монгол Улсад хэрхэн туслах вэ?*

---

ОУВС-гийн зээлийг Захирлуудын зөвлөл баталснаар эрчимтэй, тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай макро эдийн засаг, мөнгө, бүтцийн шинэчлэлийн арга хэмжээг Монгол Улсын эрх баригчдаас авч хэрэгжүүлэх явцад хөтөлбөрийн хүрээнд төсөв санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. ОУВС-гийн санхүүгийн дэмжлэгийн хүрээнд Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк болон бусад хоёр талт хандивлагчдаас нийтдээ 5.5 тэрбум орчим ам. долларын зээл, буцалтгүй тусламж олгогдоно. Ингэснээр Монгол Улсын өндөр өртөгтэй зээллэг хийх хэрэгцээ шаардлага багасч, өрийн тогтвортой байдал хангагдах нөхцөл бүрдэнэ.

### *Асуулт 2: Монгол Улсад хэрэгжүүлэх хөтөлбөрт ямар шинэчлэлийн гол арга хэмжээнүүд тусгагдсан байгаа вэ? Төсвийн бүтцийн алдагдлыг бууруулахд гол анхаарлаа хандуулах уу?*

---

Өнгөрсөн хугацаанд төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлсний уршгаар Монгол Улсын эдийн засагт одоогийн хүндрэл бэрхшээл тулгарч, өрийн хэмжээ нэмэгдсэн учраас Монгол Улсын Засгийн газрын боловсруулсан хөтөлбөр төсвийн алдагдлыг бууруулж, зарлага санхүүжилтийн сахилга батыг сахихад гол анхаарлаа хандуулна. Улс төрөөс хараат бус, бие даасан Төсвийн зөвлөлийг байгуулж, төсвийн сахилга батыг бэхжүүлэх болно. Хөтөлбөрийн хүрээнд нийгмийн хамгааллын бодлогыг шаардлагатай хэмжээнд хэрэгжүүлж, боловсрол, эрүүл мэндийн зардал тэргүүлэх чиглэлд багтаж байгаа нь чухал юм.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд эдийг засгийг солонгоруулах, нэн ялангуяа хөдөө аж ахуй, аялал жуулчлалыг салбарыг түлхүү хөгжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн нөөц бололцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бусад шинэчлэлийн арга хэмжээнүүдийг авна. Мөн түүнчлэн, бизнесийн орчинг өрсөлдөх чадвартай болгож хөгжүүлэн, хөрөнгө оруулалтыг татаж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.

### ***Асуулт 3: Шинэчлэлийн арга хэмжээнүүд нь ядууст илүү хүндээр тусах уу?***

---

Монгол Улсын эрх баригчид нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах тууштай байр суурьтай байгаа. Энэ хүрээнд боловсрол, эрүүл мэндийн салбарыг тэргүүлэх чиглэлд тавихын зэрэгцээ нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх замаар эмзэг бүлэгт ирж болзошгүй сөрөг нөлөөллийг зөөлрүүлэх болно.

Энэ зорилгоор нийгмийн халамжийн хөтөлбөр, арга хэмжээнүүдийг зорилтот бүлэгт илүү сайн чиглүүлж, оновчтой болгох болно. Тухайлбал, “Хүүхдийн мөнгө”-ийг хамгийн ядуу 40 хувьд чиглүүлж, үүнээс бий болох хэмнэлтийг хамгийн эмзэг гэсэн зорилтот бүлэгт илүү сайн чиглэгдсэн хүнсний талон хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зарцуулна. Түүнчлэн, төсвийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс хувь хүний орлогын албан татварыг шатлалтай болгож, зөвхөн өндөр орлоготой өрхийн төлөх татварын хувь хэмжээг өсгөнө.

### ***Асуулт 4: Өрийн дарамтыг хэрхэн бууруулах вэ?***

---

Хөтөлбөрийн санхүүжилтийг өрийн тогтвортой байдлыг хангах зорилттой уялдуулан шийдвэрлэх үүднээс Засгийн газар өрийг зохицуулах үйл ажиллагаа эхлүүлж байна. Энэ хүрээнд одоо байгаа хувийн хэвшлийн зээлдүүлэгчдийн оролцоог хадгалж авч үлдэх нь чухал ач холбогдолтой юм.